

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2024/58/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Говьсүмбэр аймаг</p> <p>2024 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: paranbayarg@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: Баталгаат тооцоолол аудитХХК-ийн Захирал: М.Буянбулган Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com Чанарын менежер: Г.Цогтбаатар Аудитор: Н.Цэнгэнбаяр</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.5.3 Нэмэлт төсөв	13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	13
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2024.02.22 № 41
танай _____ -ны № _____ -г

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
С.ТУЯАГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020309

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлж 74.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасныг сумын Засаг дарга 84.2 хувийн биелэлттэй дүгнэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>62,162,349.98</u>	<u>132,784,238.39</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,280,068.98	87,280,354.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,280,068.98	87,280,354.39
31211	Төрийн сангийн харилцах	19,280,068.98	87,280,354.39
35	БАРАА МАТЕРИАЛ	42,882,281.00	45,503,884.00
351	Түүхий эд материал	66,000.00	0.00
35130	Эм боох материал	66,000.00	0.00
354	Хангамжийн материал	42,816,281.00	45,503,884.00
35420	Аж ахуйн материал	908,000.00	724,300.00
35440	Түлш, шатах тослох материал	1,350,000.00	1,465,000.00
35450	Барилгын засварын материал	1,385,000.00	250,000.00
35460	Хүнсний материал	3,234,392.00	2,842,782.00
35470	Бусад хангамжийн материал	35,938,889.00	40,221,802.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,139,973,222.29</u>	<u>1,126,941,235.99</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,139,973,222.29	1,126,941,235.99
392	Биет хөрөнгө	1,032,145,722.29	1,019,203,735.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,135,779,256.76	1,135,779,256.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(129,228,101.26)	(152,887,042.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,301,757.34	49,351,225.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,501,183.45)	(25,426,082.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,639,946.65	23,137,862.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,845,953.75)	(10,751,483.63)
393	Биет бус хөрөнгө	107,827,500.00	107,737,500.00
39301	Програм хангамж	1,200,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,102,500.00)	(442,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	107,730,000.00	107,730,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,202,135,572.27</u>	<u>1,259,725,474.38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,887,650.00</u>	<u>0.00</u>
413	Өглөг	1,887,650.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,887,650.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,200,247,922.27	1,259,725,474.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	109,467,290.73	109,467,290.73
	Дахин үнэлгээний нөөц	111,988,397.48	111,988,397.48
512	Хуримтлагдсан үр дүн	978,792,234.06	1,038,269,786.17
51210	Өмнөх үеийн үр дүн	978,792,234.06	978,792,234.06
51220	Тайлант үеийн үр дүн		59,477,552.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,202,135,572.27</u>	<u>1,259,725,474.38</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,867,199,186.22	875,972,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,212,237,586.22	21,733,600.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	1,172,253,790.58	12,712,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	39,983,795.64	1,521,600.00
120009	Бусад орлого	0.00	7,500,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	105,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,454,100.00	82,806,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,454,100.00	82,806,000.00
1330	Төсвийн захирагчдаас	549,507,500.00	771,328,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	549,507,500.00	771,328,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	666,890,858.95	816,495,047.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,890,858.95	816,495,047.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,482,847.00	514,497,565.56
210101	Үндсэн цалин	406,482,847.00	411,332,819.56
210102	Нэмэгдэл	0.00	79,183,172.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	8,740,000.00
210104	Урамшуулал	0.00	15,241,574.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,286,000.52	67,203,384.03
210201	Тэтгэврийн даатгал	34,684,458.52	47,399,751.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,075,011.00	5,625,345.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,238,657.00	4,554,579.00
210204	Ажилгүйдлийн даатгал	748,511.00	969,965.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,539,363.00	8,653,744.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,771,566.27	69,790,922.97
210301	Гэрэл, цахилгаан	7,955,473.87	11,110,002.11
210302	Түлш, халаалт	52,889,511.80	51,701,712.00
210303	Цэвэр, бохир ус	6,926,580.60	6,979,208.86
2104	Хангамж, бараа материалын зардал	14,232,450.00	20,849,237.00
210401	Бичиг хэрэг	7,490,000.00	5,776,510.00
210402	Тээвэр, шатахуун	2,485,500.00	3,305,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,256,950.00	5,593,640.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	6,174,087.00
2105	Нормативт зардал	75,952,684.64	78,093,075.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	883,009.64	133,100.00
210502	Хоол, хүнс	75,069,675.00	77,959,975.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,021,000.00	5,970,000.00
210604	Урсгал засвар	9,021,000.00	5,970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	778,143.50	1,438,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	778,143.50	1,438,000.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,839,568.29	39,497,986.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,519,000.00	8,586,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,280,568.29	30,911,386.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	14,839,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	14,839,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,526,598.73	4,315,077.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,526,598.73	4,315,077.03
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,200,308,327.27	59,477,552.11

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	654,961,600.00	861,739,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	7,605,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	105,000.00
120009	Бусад орлого	0.00	7,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,454,100.00	82,806,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,454,100.00	82,806,000.00
1330	Төсвийн захирагчдаас	549,507,500.00	771,328,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	549,507,500.00	771,328,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	635,681,530.42	788,571,314.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	635,681,530.42	788,571,314.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,303,353.52	515,174,725.56
210101	Үндсэн цалин	317,470,856.52	344,032,213.56
210102	Нэмэгдэл	64,689,769.00	131,387,188.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,210,000.00	12,348,000.00
210104	Урамшуулал	15,932,728.00	27,407,324.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,525,900.00	66,526,224.03
210201	Тэтгэврийн даатгал	33,785,300.00	45,701,037.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,935,100.00	5,552,592.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,148,100.00	4,442,045.00
210204	Ажилгүйдлийн даатгал	787,100.00	983,444.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,870,300.00	9,847,106.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,746,565.67	72,490,922.97
210301	Гэрэл, цахилгаан	7,955,473.87	11,110,002.11
210302	Түлш, халаалт	55,864,511.80	54,401,712.00
210303	Цэвэр, бохир ус	6,926,580.00	6,979,208.86
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	0.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	0.00
2105	Нормативт зардал	77,681,570.00	77,568,365.00
210502	Хоол, хүнс	77,681,570.00	77,568,365.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,980,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	6,980,000.00	6,000,000.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	938,142.50	1,522,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	938,142.50	1,522,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,875,900.00	30,134,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,345,900.00	25,568,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,530,000.00	4,566,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	14,839,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	14,839,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,526,598.73	4,315,077.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,526,598.73	4,315,077.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,280,069.58</u>	<u>73,167,685.41</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	(5,167,400.00)
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	(5,167,400.00)
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>0.00</u>	<u>(5,167,400.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	19,280,069.58	68,000,285.41
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	19,280,068.98
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,280,069.58	87,280,354.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,467,290.73	111,988,397.48	978,792,234.06	1,200,247,922.27
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	109,467,290.73	111,988,397.48	978,792,234.06	1,200,247,922.27
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,467,290.73	111,988,397.48	978,792,234.06	1,200,247,922.27
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	59,477,552.11	59,477,552.11
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,467,290.73	111,988,397.48	1,038,269,786.17	1,259,725,474.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /				
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		19,280,068.98	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	754,255,100.00	710,872,714.59	94.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	754,255,100.00	710,872,714.59	94.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	739,415,300.00	696,032,914.59	94.1

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	554,868,600.00	515,174,725.56	92.8
210101	Үндсэн цалин	366,649,400.00	344,032,213.56	93.8
210102	Нэмэгдэл	147,989,400.00	131,387,188.00	88.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,833,100.00	12,348,000.00	56.6
210104	Урамшуулал	18,396,700.00	27,407,324.00	149.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,630,100.00	66,526,224.03	99.8
210201	Тэтгэврийн даатгал	45,308,300.00	45,701,037.00	100.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,330,200.00	5,552,592.03	104.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,264,600.00	4,442,045.00	104.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,066,400.00	983,444.00	92.2
210205	Эрүүл мэндийн даатгал	10,660,600.00	9,847,106.00	92.4
2105	Нормативт зардал	92,386,000.00	77,568,365.00	84.0
210502	Хоол, хүнс	92,386,000.00	77,568,365.00	84.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,522,000.00	1,522,000.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,522,000.00		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,522,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,008,600.00	35,241,600.00	146.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,442,500.00	30,675,500.00	157.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,566,100.00	4,566,100.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,839,800.00	14,839,800.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,839,800.00	14,839,800.00	100.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	754,255,100.00	771,328,000.00	102.3
31	Улсын төсвөөс санхүүжих	754,255,100.00	771,328,000.00	102.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	754,255,100.00	771,328,000.00	102.3
12	Татварын бус орлого		105,000.00	
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/		105,000.00	

Аудит хийсэн Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,806,000.00	78,490,922.97	94.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,806,000.00	78,490,922.97	94.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,806,000.00	72,490,922.97	94.4
210301	Гэрэл, цахилгаан	13,000,000.00	11,110,002.11	85.5
210302	Түлш, халаалт	56,806,000.00	54,401,712.00	95.8
210303	Цэвэр, бохир ус	7,000,000.00	6,979,208.86	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	6,000,000.00	100.0
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00	100.0
71801	Сургуулийн өмнөх боловсрол	82,806,000.00	82,806,000.00	100.0
12	Татварын бус орлого	82,806,000.00	82,806,000.00	100.0

122005	Төсвөөс санхүүжих	82,806,000.00	82,806,000.00	100.0
--------	-------------------	---------------	---------------	-------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Тайлант онд нэмэлт санхүүжилт хийгдээгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд сургуулийн өмнөх боловсролын зорилгыг бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино гэж чиг, үүргийг хуулийн 5.1, 5.2, 5.3 заалтад тодорхойлсон зорилго, үндсэн чиг үүрэг бүхий аймгийн Боловсролын газрын харьяа байгууллага юм.

Тайлант онд жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлж 74.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасныг сумын Засаг дарга 84.2 хувийн биелэлттэй дүгнэсэн байна.

2023 оны нийт төлөвлөгдсөн зардлын санхүүжилтийн эх үүсвэр улсын төсвийн төлөвлөгөө 754,255.1 мянган, гүйцэтгэл 710,932.7 мянган төгрөг буюу гүйцэтгэл 94.3 хувийн, орон нутгийн төсвийн төлөвлөгөө 82,806.0 мянган, гүйцэтгэл 78,490.9 мянган төгрөг буюу 94.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол ;

- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллага дотоод хяналтын чиг үүргийг газрын даргын тушаалаар батлагдсан журам зааврыг мөрдлөг болгодог. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул байгууллагын дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар түүнийг аудитад ашиглахгүй гэж үзлээ.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны хувьд Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хуулиудад нийцүүлэн гарсан дээд шатны байгууллагуудын тогтоол, журам, тушаал, шийдвэрүүдийг өөрийн үйл ажиллагаандаа эрхлэгчийн тушаалаар тухай бүрт нь өөрчлөлт оруулан мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэг аймгийн хэмжээнд нийтлэг мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,589.9 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,280.7	87,280.4	68,000.3
Бараа материал	42,882.3	45,503.9	2,621.6
Үндсэн хөрөнгө	1,139,973.2	1,126,941.2	-13,032.0
Нийт хөрөнгө	1,202,135.6	1,259,725.5	57,589.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,200,247.9	1,259,725.5	59,477.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,202,135.6	1,259,725.5	57,589.9

Дээрх хүснэгтээс харахад, дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 68,000.3 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн сангаас гүйлгээ хаах өдөр санхүүжилт орж ирсэн тул дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 2,621.6 мянган төгрөгөөр өсөхөд гүйцэтгэлийн үнэлгээгээр 2-р түвшинд үнэлэгдсэн тул урамшууллын 30 хувиараа бараа материал худалдан авсан нь нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 13,032.0 мянган төгрөгөөр буурахад ашиглах хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон хөрөнгүүдийг акталж данснаас хассантай холбоотой;

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 705,312.4 мянга, орон нутгийн төсвөөс 67,441.2 мянга, нийт зарлагыг 772,753.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс 62,618.0 мянган төгрөгөөр зардлыг бууруулж, орон нутгийн төсвийг 8,364.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 718,500.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн хэмнэлтийн хууль болон бусад хуулиудад өөрчлөлт орсонд нийцүүлсэнтэй холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 135,633.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 834,942.0 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 771,328.0 мянга, орон нутгийн төсвөөс 82,806.0 мянга нийт 854,134.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаандаа улсын төсвийн 691,547.7 мянга, орон нутгийн төсвийн 78,491.0 мянга нийт 770,038.7 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвийн данснаас төвлөрүүлэх шилжүүлэг хийгээгүй ба орон нутгийн төсвийн санхүүжилтээс 4,315.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсвийн 79,780.4 мянган төгрөг харилцах дансны үлдэгдэлтэй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт олгоогүй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд 105,922.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч орлогоор бүртгэсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, чанарын менежер Г.Цогтбаатар нар гүйцэтгэж, хяналтыг захирал М.Буянбулган болон Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлсэн.

2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 666,890.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 6,668.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Учир нь 2023 онд зарим эрх зүйн актуудад өөрчлөлт орсонтой холбоотой. Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 816,495.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож, материаллаг байдлыг 8,1645.0 мянган төгрөгөөр тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай 32 заалтын хэрэгжилтэд аудитын горим, сорил гүйцэтгэхээр төлөвлөж, хяналтыг хэрэгжүүлэв. Байгууллага төсвийн үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Хуулийн хүрээнд төсвийн хэмнэлтийг авч үзэхэд нийт урсгал зардал 43,382.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Үүнд: Цалин хөлс, болон нэмэгдэл урамшуулал

39,693.9 мянган болон ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл 103.9 мянган, нормативт зардлыг 14,817.6 төгрөгөөр дутуу зарцуулсан нь нөлөөлжээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд батлагдсан төсвийн хөрөнгийн хүрээнд худалдан авах төлөвлөгөөг боловсруулж байршуулаагүй, 5 саяас дээш 5.5 сая төгрөгийн 1 гүйлгээг орхигдуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмын 3 дугаар зүйлийн 3.2.10-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Үндэсний аудитын газраас зарласан сонгон шалгаруулалтаар Говьсүмбэр аймгийн багц 1-д тэнцэж, гурвалсан гэрээг 2023 оны 10 дугаар сарын 13-нд байгуулж, аудитын нээлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай шалгагдагч байгууллагуудын удирдлага, нягтлан бодогчдыг оролцуулан хийв. Завсрын аудитыг эхний 9 сарын санхүүгийн болон холбогдох баримт, байгууллагын үйл ажиллагаатай биечлэн танилцах ажилбаруудыг гүйцэтгэж, илэрсэн алдаа, зөрчлийн асуудлыг байгууллагын удирдлагад танилцуулж, уулзалтын тэмдэглэлээр баримтжуулсан.

Асуудлын бүртгэлийг жилийн дүнгээр нэгтгэн танилцуулж шийдвэрлүүлэхээр тогтсон болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлагын хэрэгжилтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 01/155 тоот албан бичгээр хүргүүлсэн байв.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	2	408,968.8	2	408,968.8	100.0
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	2	408,968.8	2	408,968.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн хэмжээнд нийтлэг мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигтэй ба энэ байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгасан эсэх, эрхлэгчийн гаргасан зарим тушаалын заалт Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын холбогдох тушаалын заалттай нийцүүлээгүй, гүйцэтгэлийн талаар тодорхой тусгахгүй байгаад анхаарах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,790.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн бөгөөд зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдааг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага тус бүр 1-ийг өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон боловч цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Зөрчилгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр нягтлан бодогч Б.Цэрэнбатад сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээний буюу 1,292,235.00 төгрөг тооцож урамшуулалд давхардуулан олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 40.3 дэх "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ", Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна." Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалтыг тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Давхардуулан олгосон урамшууллыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

1. Дотоод хяналт холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын тайлан, анхан шатны баримтуудтай танилцахад агуулахын бүртгэл хөтөлдөггүй, зарим баримтын гарын үсгийн баталгаажуулалт дутуу байсан нь холбогдох журмын зааврыг бүрэн мөрдлөг болгож хэвшүүлээгүйтэй холбоотой байна. Тухайлбал: НХМаягт БМ-5, цалингийн тооцооны хүснэгт

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журмын тухайн маягтуудыг хөтлөх, гүйцэтгэлд хяналт тавих зааврыг мөрдлөг болгоогүйтэй холбоотой байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Агуулахын бүртгэл болон цалингийн тооцооны хүснэгтийг зааврын дагуу хөтөлж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Урамшуулал давхардуулан олгосон	1	1,292.2	1	1,292.2	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	1,292.2	1	1,292.2	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн данстай холбоотой	1	0.0	-	-	1	5,498.7	-	-
Дотоод хяналт	1	0.0	-	-	-	-	1	0.0
Дүн	2	5,498.7	-	-	1	5,498.7	1	0.0

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР